



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Ор хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны А/132 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Самандбадраа” ХХК-ийн эмнэлэгт өвчний архаг үеийн уламжлалтын 5 ор нэмэлтээр, “Эрүүл энх баяс” ХХК-ийн эмнэлэгт өвчний хурцавтар үеийн 10 ор нэмэлтээр, “Нууц увидас рашаан” ХХК-ийн эмнэлэгт өвчний архаг үеийн уламжлалтын 10 ор нэмэлтээр, “Очир дэлэг” ХХК-ийн эмнэлэгт өвчний хурцавтар үеийн 15 ор, “Энхсаран” ХХК-ийн сувилалд сувиллын 30 ор нэмэлтээр, “Жаргалан сувилал” ХХК-ийн сувилалд сувиллын 15 ор тус тус хуваарилсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагын батлагдсан орны хязгаарт багтаан үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс /Г.Баянжаргал/-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500171